

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/206/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН БУМБАРДАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт .....	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/90  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН  
БУМБАРДАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Н.ОТГОНЧИМЭГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020312

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>40,161,357.73</b>	<b>41,840,570.16</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,189,396.00	600.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	467,796.00	
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,721,600.00	600.00
3351	Байгууллагаас авах авлага	1,721,000.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	600.00	600.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	37,971,961.73	41,839,970.16
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	45,000.00
35130	Эм боох материал		45,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	37,971,961.73	41,794,970.16
35420	Аж ахуйн материал		186,150.00
35450	Барилгын засварын материал		557,200.00
35460	Хүнсний материал		3,444,770.00
35470	Бусад хангамжийн материал	37,971,961.73	37,606,850.16
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>962,786,461.46</b>	<b>925,820,916.50</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	962,786,461.46	925,820,916.50
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	889,470,628.54	852,560,083.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	901,399,190.36	901,399,190.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	54,547,299.60	81,820,949.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,035,413.60	41,035,413.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	23,673,008.28	28,494,524.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,640,037.18	53,124,037.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	27,383,704.72	32,683,083.76
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	73,315,832.92	73,260,832.84
39301	Программ хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	284,167.08	339,167.16
39303	Бусад биет бус хөрөнгө	73,160,000.00	73,160,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,002,947,819.19</b>	<b>967,661,486.66</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,857,578.97</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	1,857,578.97
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	1,857,578.97
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	1,857,578.97
41361	Байгууллагад төлөх өглөг		1,857,578.97
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,002,947,819.19</b>	<b>965,803,907.69</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,002,947,819.19	965,803,907.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,054,952,210.78	1,054,952,210.78
51101	Өмч: - төрийн	1,054,952,210.78	1,054,952,210.78
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(297,177,030.44)	(334,320,941.94)
51210	Өмнөх үеийн үр дүн	(297,177,030.44)	(297,177,030.44)
51220	Тайлант үеийн үр дүн		(37,143,911.50)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	245,172,638.85	245,172,638.85
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,002,947,819.19</b>	<b>967,661,486.66</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>383,422,140.90</b>	<b>359,268,950.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,257,340.90</b>	<b>529,750.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	300,000.00
120009	Бусад орлого		300,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	9,257,340.90	229,750.00
122001	Хандив тусламж /дотоод/	9,257,340.90	229,750.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>374,164,800.00</b>	<b>358,739,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	300,274,100.00	291,312,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	300,274,100.00	291,312,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,623,900.00	9,160,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,623,900.00	9,160,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	58,266,800.00	58,266,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,266,800.00	58,266,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>412,786,762.35</b>	<b>396,412,861.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>412,786,762.35</b>	<b>396,412,861.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	324,660,844.00	336,782,487.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	199,886,615.96	211,596,565.39
210101	Үндсэн цалин	143,345,163.57	159,415,263.08
210102	Нэмэгдэл	43,572,315.39	52,181,302.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,508,000.00	
210104	Урамшуулал	10,461,137.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,613,403.60	25,375,161.07
210201	Тэтгэврийн даатгал	18,417,460.60	22,128,130.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,802,135.00	827,507.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,438,348.00	645,206.00
210204	Ажилгүйдлийн даатгал	359,586.00	161,301.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,595,874.00	1,613,017.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,487,442.00	46,078,635.00
210301	Гэрэл, цахилгаан	36,921,048.00	41,202,885.00
210303	Цэвэр, бохир ус	4,566,394.00	4,875,750.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,177,469.18	2,486,021.57
210401	Бичиг хэрэг	200,800.00	177,800.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	195,800.00
210404	Ном, хэвлэл		17,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		272,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,199,871.00	541,910.00
210408	Бараа материал акталсны зардал	1,426,798.18	1,130,111.57
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,018,999.00	10,850,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,900.00	

**Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	14,404,199.00	9,051,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	555,900.00	1,798,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>571,225.00</b>	<b>503,030.00</b>
210604	Урсгал засвар	571,225.00	503,030.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>432,000.00</b>	<b>-</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	432,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,473,689.26</b>	<b>39,892,824.96</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,138,325.66	1,521,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	725,939.00	921,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,609,424.60	37,449,544.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>88,125,918.35</b>	<b>59,630,373.51</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,623,900.00</b>	<b>9,160,100.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,623,900.00	9,160,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>56,222,660.35</b>	<b>38,782,108.51</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,222,660.35	38,782,108.51
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>16,279,358.00</b>	<b>11,688,165.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,279,358.00	11,688,165.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(29,364,621.45)</u></b>	<b><u>(37,143,911.50)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(29,364,621.45)</u></b>	<b><u>(37,143,911.50)</u></b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,054,952,210.78	245,172,638.85	-267,812,408.90	1,032,312,440.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,054,952,210.78</b>	<b>245,172,638.85</b>	<b>-267,812,408.90</b>	1,032,312,440.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-29,364,621.54	-29,364,621.54
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,054,952,210.78</b>	<b>245,172,638.85</b>	<b>-297,177,030.44</b>	1,002,947,819.19
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,054,952,210.78</b>	<b>245,172,638.85</b>	<b>-326,541,651.98</b>	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,054,952,210.78</b>	<b>245,172,638.85</b>	<b>-297,177,030.44</b>	1,002,947,819.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-37,143,911.50	-37,143,911.50
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,054,952,210.78</b>	<b>245,172,638.85</b>	<b>-334,320,941.94</b>	965,803,907.69

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>376,296,600.00</b>	<b>359,039,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,131,800.00</b>	<b>300,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,131,800.00	300,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2,131,800.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,131,800.00	
120009	Бусад орлого		300,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>374,164,800.00</b>	<b>358,739,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	300,274,100.00	291,312,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	300,274,100.00	291,312,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,623,900.00	9,160,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,623,900.00	9,160,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	58,266,800.00	58,266,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,266,800.00	58,266,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>376,296,600.00</b>	<b>358,555,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>376,296,600.00</b>	<b>358,555,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>288,170,681.65</b>	<b>298,924,826.49</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	199,950,136.22	208,072,479.03
210101	Үндсэн цалин	144,477,283.74	157,557,684.11
210102	Нэмэгдэл	42,503,715.39	50,514,794.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,508,000.00	
210104	Урамшуулал	10,461,137.09	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,017,679.43	26,573,872.46
210201	Тэтгэврийн даатгал	22,454,195.83	19,560,691.00
210202	Тэтгэмжийн даатгал	845,504.09	1,762,745.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	858,030.51	1,400,116.31
210204	Ажилгүйдлийн даатгал	168,940.79	350,029.03
210205	Эрүүл мэндийн даатгал	1,691,008.21	3,500,290.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,487,442.00	46,078,635.00
210301	Гэрэл, цахилгаан	36,921,048.00	41,202,885.00
210302	Түлш, халаалт	4,566,394.00	4,875,750.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,841,386.00	2,685,370.00
210401	Бичиг хэрэг	200,000.00	200,000.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	195,800.00
210404	Ном, хэвлэл		50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		273,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,291,386.00	1,816,070.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16,379,899.00	12,570,470.00

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,900.00	45,000.00
210502	Хоол, хүнс	15,570,999.00	10,775,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,000.00	1,749,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>432,000.00</b>	<b>-</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	432,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,562,139.00</b>	<b>2,444,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	835,400.00	1,537,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	726,739.00	907,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>88,125,918.35</b>	<b>59,630,373.51</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,623,900.00</b>	<b>9,160,100.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,623,900.00	9,160,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>56,222,660.35</b>	<b>38,782,108.51</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,222,660.35	38,782,108.51
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>16,279,358.00</b>	<b>11,688,165.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,279,358.00	11,688,165.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>484,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>484,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>484,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>484,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		484,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(484,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	349,579,100.0	299,298,756.5	50,280,343.5	85.6
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	349,579,100.0	299,298,756.5	50,280,343.5	85.6
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	349,579,100.0	299,298,756.5	50,280,343.5	85.6
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	229,924,600.0	205,789,665.0	24,134,935.0	89.5
210101	Үндсэн цалин	147,076,100.0	157,557,684.1	(10,481,584.1)	107.1
210102	Нэмэгдэл	51,501,700.0	50,514,794.9	986,905.1	98.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,360,000.0		8,360,000.0	-
210104	Урамшуулал	22,986,800.0	(2,282,814.0)	25,269,614.0	(9.9)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,039,800.0	28,856,686.5	2,183,113.5	93.0
210201	Тэтгэврийн даатгал	21,842,900.0	19,705,191.0	2,137,709.0	90.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,299,300.0	2,528,945.4	(229,645.4)	110.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,839,400.0	2,013,016.3	(173,616.3)	109.4
210204	Ажилгүйдлийн даатгал	459,900.0	503,229.0	(43,329.0)	109.4
210205	Эрүүл мэндийн даатгал	4,598,300.0	4,106,304.8	491,995.3	89.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	57,766,800.0	46,078,635.0	11,688,165.0	79.8
210301	Гэрэл, цахилгаан	47,959,600.0	41,202,885.0	6,756,715.0	85.9
210303	Цэвэр, бохир ус	9,807,200.0	4,875,750.0	4,931,450.0	49.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,090,000.0	3,059,300.0	30,700.0	99.0
210401	Бичиг хэрэг	200,000.0	200,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	150,000.0	150,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.0	195,800.0	4,200.0	97.9
210404	Ном, хэвлэл	50,000.0	50,000.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.0	273,500.0	26,500.0	91.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.0	2,190,000.0	-	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	24,713,900.0	12,570,470.0	12,143,430.0	50.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.0	45,000.0	-	100.0
210502	Хоол, хүнс	22,918,900.0	10,775,720.0	12,143,180.0	47.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,750,000.0	1,749,750.0	250.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.0	500,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	500,000.0	500,000.0	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	100,000.0	-	100,000.0	-
210702	Дотоод албан томилолт	100,000.0		100,000.0	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,444,000.0	2,444,000.0	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,537,000.0	1,537,000.0	-	100.0

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	907,000.0	907,000.0	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	349,579,100.0	349,579,100.0	-	100.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	291,312,300.0	291,312,300.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,312,300.0	291,312,300.0	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	58,266,800.0	58,266,800.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	58,266,800.0	58,266,800.0	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/
			Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,270,170.00</b>	<b>9,270,170.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,270,170.00</b>	<b>9,270,170.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	110,070.00	110,070.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	110,070.00	110,070.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	110,070.00	110,070.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,160,100.00	9,160,100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,160,100.00	9,160,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,160,100.00	9,160,100.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	9,160,100.00	9,160,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,160,100.00	9,160,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,160,100.00	9,160,100.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Жишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг нь бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйл ажиллагааг танхимын болон зайны сургалтын хэлбэрийг хослуулан, үе шаттайгаар чанартай зохион байгуулж, эцэг эх асран хамгаалагчийн дэмжлэг оролцоог бүхий л хэлбэрээр дэмжин, суралцахуйд тулгарч буй бэрхшээлийг арилгах замаар хүүхэд бүрийг ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН болгон төлөвшүүлэхийг эрхэм зорилгоо болгон анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрхлэгчийн тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан, сар бүр дотоод хяналтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн, дотоод хяналтын ажлын үр дүнг тайлагнан ажилласан.

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 349,579.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,243.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,932.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### ***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 291,312.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 58,266.8 мянган төгрөгийн, нийт 349,579.1 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 9,270.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 44,379.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### ***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 484.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 484.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 484.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 229.8 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 16,537.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 12,898.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

**Авлага, өглөгийн талаар:**

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 0.6 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой авлага, 1,857.6 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна.

Бараа материал 41,840.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 925,820.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,189.39	0.60	(2,188.79)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	37,971.96	41,839.97	3,868.01
Үндсэн хөрөнгө	962,786.46	925,820.92	(36,965.54)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,002,947.81</b>	<b>967,661.49</b>	<b>(35,286.32)</b>
Өр төлбөр	-	1,857.58	1,857.58
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,002,947.81	965,803.91	(37,143.90)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,002,947.81</b>	<b>967,661.49</b>	<b>(35,286.32)</b>

Авлагын дансны үлдэгдэл 0.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 2,188.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх оны авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41,839.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 3,868.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 925,820.9 мянган төгрөг болж 36,965.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,857.6 мянган төгрөг болж оны эхний үлдэгдлээс 1,857.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 965,803.9 мянган төгрөг болж 37,143.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 349,579.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 349,579.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 349,579.1 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 291,312.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 58,266.8 мянган төгрөгийн, нийт 349,579.1 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 299,298.8 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 50,280.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 299,298.8 мянган төгрөг буюу 85.6 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 9,270.2 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 110.7 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд 9,160.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Бараа материалын дансанд 186.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 557.2 мянган төгрөгийн барилгын материал, 3,444.8 мянган төгрөгийн хүнсний материал, 37,606.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материалын үлдэгдэлтэй бараа материалын нөөц бүрдүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 9 нэр төрлийн 3,207.9 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 4 нэр төрлийн 1,017.6 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй, шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 92 мэдээллийг хугацаандаа, 26 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг мэдээлээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 92 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 26 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 415.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2,372.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдөж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 4,225.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,225.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитын явцад залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.3 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бараа материалын данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 9 нэр төрлийн 3,207.9 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах

#### **2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 4 нэр төрлийн 1,017.6 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

#### **3. Шилэн данстай холбоотой асуудал**

##### **3.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 92 мэдээллийг хугацаандаа, 26 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, мөн хуулийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг	3	4,225.5	-	-	-	-	-	-	3	4,225.5

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)